



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2023/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Булган аймаг 2024 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 143
танай _____ ны № _____ т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.АМГАЛАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

НББ-ийн 23 дугаар 23.2 дахь заалтыг үндэслэн ХХААГ-ын даргын 2023 оны Б/38 дугаар тушаалаар үр бүтээлтэй ажилласан талаар үнэлээгүй, үр дүнгийн урамшуулалтай давхардуулан нэг сарын цалингаар урамшуулал олгосон,

Засаг даргын нөөц хөрөнгөөс нэмэлт санхүүжилтийн дансанд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор шилжүүлсэн хөрөнгийг зарцуулахдаа худалдан авах ажиллагаа зарлаагүй, хөрөнгө зарцуулах тушаал шийдвэргүй, гэрээ кантрант байгуулаагүй, зориулалт бусаар анхан шатны баримтын бүрдэлгүй хангалтгүй, хэн хэзээ төлөх нь тодорхойгүй шаардах хуудсаар зарцуулсан зэрэг алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргаар 93.5 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын

000020664

шимтгэлээрээ балансын үнэ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон тавилга эд хогшил, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамжийг акталж, данснаас хасах асуудлыг судлан шийдвэрлэх шаардлагатай 106 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	94,901.6	104,911.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	357,826.6	335,978.4
	Нийт хөрөнгийн дүн	452,728.2	440,889.3
	Нийт өр төлбөрийн дүн	6,486.5	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	446,241.7	440,889.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	452,728.2	440,889.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	467,119.2	922,762.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	460,104.7	891,182.7
	Үйл ажиллагааны үр дүн	7,014.5	31,579.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	(29,448.3)	(36,931.7)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(22,433.8)	(5,352.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	472,897.1	449,036.9
	Тайлант оны үр дүн	(22,433.8)	(5,352.3)
	Эцсийн үлдэгдэл	450,463.3	443,684.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	419,002.4	881,780.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	419,002.4	881,780.9
	Үйл ажиллагааны ЦМГ	-	(0.0)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	(0.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		670,814.4
	Урсгал зардал		670,814.4
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		670,814.4
	Улсын төсвөөс санхүүжих		670,814.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 768,753.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 41,671.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 722,603.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,479.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 39,247.6 мянган төгрөгөөр их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1.Цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн хоёр албан хаагчид 2023 оны 1 дүгээр сард 1,167.0 мянган төгрөгийн цалин олгосон байна нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.5, 2.6 дахь заалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-д “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн”, 4.2.3.8-д “*төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*” заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

2. Аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2022 оны хамтын ажиллагааны гэрээний хөрөнгө оруулалтаас Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж олгосон 40,000.0 мянган төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэргүй, хэн хэзээ төлөх нь тодорхойгүй, гэрээ кантракт байхгүй, эрх мэдлээ хэтрүүлэн, зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 47.2, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлийг тус тус хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэгн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 590,508.3 мянган төгрөгийн 11 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 132,095.4 мянган төгрөгийн 5 гүйлгээ, байгууллагын батлагдсан төсвийг 31 гүйлгээ зөрүүтэй мэдээлсэн, нийт 159 мэдээлэл мэдээлэхээс дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, хагас жилийн санхүүгийн тайлан нийт 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө

¹Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зарцуулах 14,254.3 мянган төгрөгийн 22 шийдвэрийг мэдээлээгүйд албан шаардлага өгч ажиллагаа.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайлангийн 39203, 39205, 39207 дансанд анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн буюу 0 үлдэгдэлтэй 106 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх заавар үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн тайланд ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнэ нөхсөн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөл, холбогдох газруудад шийдвэрлүүлэх ажил зохион байгуулан, УСНББОУС-17 мөрдөж ажиллах.

1.2 Илрүүлэлт: Тушаал шийдвэргүйгээр албан томилолтыг зарцуулсан, мөн томилолтын шатахууныг тээвэр шатахууны зардлаар тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж: Зардлыг бодитой төлөвлөж, төсөвт байгууллагын дагаж мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын журмыг хэрэгжүүлэн үнэн зөв тайлагнаж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)									
Алдааны товч утга	Нийт алдаа		НББ-ын бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		
							Залруулсан		Зөвлөмж
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Залруулга хийгдээгүй.									
Дүн									

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо Дүн
НББ-ийн 23 дугаар 23.2 дахь заалтыг үндэслэн ХХААГ-ын даргын 2023 оны Б/38 дугаар тушаалаар үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал авсан.	1	1,671.0	1	1,671.0					
Булган сумын оёдлын цехийн үйл ажиллагаанд зориулж олгосон 40.0 сая төгрөгийг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрөнгө зарцуулах шийдвэргүй, хэн	1	40,000.0	1	40,000.0					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түвшэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Хүнс, хөдөө аж ахуйн газар ТШЗ-ийн дүн	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр	1	1				1		
3	ЗГПС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		